



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 4/333

Улаанбаатар хот

Хан-Уул дүүргийн 41 дүгээр сургуулийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 63,774,179.00 /жаран гурван сая долоон зуун далан дөрвөн мянга нэг зуун далан есөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Хан-Уул дүүргийн 41 дүгээр сургууль /И.Батбаяр/-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 58,247,115.0 /тавин найман сая хоёр зуун дөчин долоон мянга нэг зуун арван таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 6 нэр төрлийн нийт 5,527,064.0 /таван сая таван зуун хорин долоон мянга жаран дөрвөн төгрөгийн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 41 дүгээр сургууль /И.Батбаяр/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ~~

Ш.ҮНЭНБАТ

115050000749

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 06 дугаар сарын 29-ий өдрийн
0603... дугаар тушаалын хавсралт

Хөрөнгө данснаас хасах тухай

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 41 дүгээр сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	ЭБХХК-ын шийдвэр
нийтийн эзэмшил											
1	хатуу хучилттай талбай	49	м2	1665	16,475	27,430,875.00	879,194.70	26,551,680.30	хуучирсан	актлах	устгах
2	Сагсны талбай	24	м2	1768	17,430	30,816,240.00	2,554,760.00	28,261,480.00	хуучирсан	актлах	устгах
3	Хашаа төмөр	49	м2	156	29,134	4,544,904.00	441,461.05	4,103,442.95	шинэ хашаа хийх болсон	актлах	татах
Нийтийн эзэмшлийн дүн						62,792,019.0	3,875,415.75	58,916,603.25			
Тоног төхөөрөмж											
1	Дриль батерей	4	ш	2	25,000	50,000.0	50,000.00	-	актлах	актлах	татах
2	Дриль	5	ш	1	125,000	125,000.0	106,249.83	18,750.17	актлах	актлах	татах
3	Принтер	5	ш	1	308,000	308,000.00	308,000.00	-	актлах	актлах	татах
4	Хөрөө харуулын суурь машин	22	ш	1	434,160	434,160.00	434,160.00	-	актлах	актлах	татах
5	Таслагч	5	ш	1	65,000	65,000.00	55,249.83	9,750.17	актлах	актлах	татах
Тоног төхөөрөмжийн дүн				6		982,160.00	953,659.66	28,500.34			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						63,774,179.00	4,829,075.41	58,945,103.59			
Үүнээс татан төвлөрүүлэх хөрөнгө						5,527,064.00					
Актлах хөрөнгө						58,247,115.00					